



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар A/17

Мандалговь

Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 130.2, аймгийн Засаг даргын Тамгын газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 31.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 18.3 дахь заалтын “Цалинтай болон цалингүй чөлөөг эдлэх хугацаа хагас жил тутамд төрөл тус бүрд ажлын 5 өдрөөс илүүгүй байх” гэдгийг “Цалинтай болон цалингүй чөлөөг эдлэх хугацаа хагас жил тутамд төрөл тус бүрд ажлын 2 өдрөөс илүүгүй байх” гэж өөрчилсүгэй.

Хоёр. “Хөдөлмөрийн дотоод журам”-ын өөрчилсөн заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг байгууллагын нийт ажилтан албан хаагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (М.Цогзолмаа) –т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЭРДЭНЭСҮРЭН

0300172